

ШИХИХУТУГ

Цуврал 33, Дугаар 2, 2025 оны 10 сар, хуудас 170-189
<https://shu.edu.mn/journal>



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙГ ЭГҮҮЛЭН ТАТАХАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ISSUES ARISING IN THE REMOVAL OF A MEMBER OF THE STATE GREAT KHURAL WHO HAS COMMITTED A CRIME

Б.Билэгдэмбэрэл¹

National University of Mongolia, E-mail: bilgebold58@gmail.com

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Keywords:

A Member of the State Great Khural who has committed a crime, Immunity of a Member of Parliament, Ballot, Judicial authority, Right to vote, Right to be elected, Criminal responsibility, Principle of justice

Түлхүүр үгс:

Гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүн, УИХ-ын гишүүний халдашгүй байдал, санал хураалт, парламентын бие даасан байдал, шүүх эрх мэдэл, сонгох эрх, сонгогдох эрх, эрүүгийн хариуцлага, шударга ёсны зарчим.

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 9 сар
Шинэчилсэн: 2025, 10 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

ХУРААНГУЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд УИХ түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна. Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах журам тодорхойгүй, логик зөрчилтэйн улмаас хууль тогтоогчид хариуцлага тооцох Үндсэн хуулийн заалт хэрэгжих боломжгүй болжээ. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүнийг эгүүлэн татахдаа санал хураалт явуулж олонхын санал авсан тохиолдолд эгүүлэн татахаар заасан нь гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон л бол заавал эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж байна. Түүнчлэн, нэр бүхий УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон² боловч өнөөдрийг хүртэлх хугацаанд УИХ түүнийг эгүүлэн татахгүй байх нөхцөл байдал үүссэн нь энэхүү зөрчилдөөний үр дагавар болж байна.

Abstract

According to Article 29, Paragraph 3 of the Constitution of Mongolia, a member of the State Great Khural (Parliament) shall be removed from office if it is established by a legally binding court decision that the member has committed a crime. However, due to the lack of a clear procedure and logical inconsistencies in the Law on the State Great Khural of Mongolia and the Law on the Rules of Procedure of the State Great Khural, the constitutional provision for holding lawmakers accountable cannot be effectively implemented. Specifically, the Law on the State Great Khural stipulates that a member who has committed a crime shall be removed from office only if a vote is held and a

¹МУИС, Хууль Зүйн Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн судлаач

² УИХ-ын гишүүн Д.Ц нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдож, нийтийн албанд томилогдох эрхээ 2 жил хасуулж, 20 сая төгрөгийн торгох ял шийтгэгдсэн. Улсын Дээд шүүхийн тогтоол 2024.12.11-ны өдөр гарсан боловч тэрээр өнөөдрийг хүртэл (2025.09.10) УИХ-ын гишүүний ажлаа хийсээр байгаа юм. (Хөгжлийн банкны гэх 80 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох хэргийн шийдвэрийн тойм, Сүүлд хандсан огноо: 2025.08.28.
<https://www.supremecourt.mn/mn/home?page=pages&id=58&pg=3406&pr=14&tp=list&h=0>)

Article history:

Received Sep, 2025

Revised Oct, 2025

Accepted Oct, 2025

majority is obtained, which contradicts the principle of the Constitution that removal is mandatory once it is established that a crime has been committed. Moreover, the fact that certain members of the State Great Khural have been legally found guilty of crimes by court decisions, yet have not been removed from office to date, reflects the practical consequence of this inconsistency.

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.

**1. Танилцуулга**

Ард иргэд нэгдмэл эрх ашиг, тогтвортой нийгмийн хэв журмыг хангуулахын тулд өөрсдийн эрх, эрх чөлөөний тодорхой хэсгийг төрд шилжүүлдэг бөгөөд үүний үргэлжлэл болгон сонгож байгуулсан парламентдаа хяналт тавьж, гишүүдийг нь хариуцлагажуулах боломжтой байх нь ардчилсан тогтолцооны зайлшгүй шаардлага юм. Төрийн байгууллага, албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах эрсдэл байнга оршдог тул олон улс парламентын гишүүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох, эрүүгийн болон улс төрийн хариуцлага оногдуулах тогтолцоог эрх зүйдээ тусгаж иржээ. Монгол Улс ч мөн адил 1992 оны Үндсэн хуульдаа шүүхээс гэм буруутай гэж тогтоосон УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах зохицуулалтыг хуульчилсан нь парламентын хариуцлагыг бэхжүүлэх чухал ахиц болсон. Гэвч энэ зохицуулалтыг ердийн хуулиар хэрэгжүүлэхдээ эгүүлэн татах асуудлыг санал хураалтаар шийдвэрлэх хэлбэрт шилжүүлсэн нь шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх зарчимтай зөрчилдөх эрсдэл дагуулж буй тул парламентын гишүүний гэмт хэрэгтэй холбоотой хариуцлагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын нийцлийн асуудлыг онол-практикийн түвшинд дахин авч үзэх шаардлага үүсээд байна. Иймд энэхүү илтгэлээр УИХ-ын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эгүүлэн татах эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлыг тодорхойлон шинжилж, олон улсын туршлага, түүхэн хөгжил, парламентын дархан эрхийн үзэл баримтлалтай уялдуулан авч үзэж, зохицуулалтыг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргахыг зорилоо.

2. Арга зүй

Энэхүү илтгэлийн хүрээнд парламентын гишүүний гэмт хэрэгтэй холбоотой хариуцлагын зохицуулалтыг хууль зүйн догматик шинжилгээ, харьцуулсан эрх зүйн арга, түүхэн-хөгжлийн анализ, мөн шүүхийн шийдвэр, парламентын практикт суурилсан бодит кейсийн судалгааг ашиглан судалсан байна. Хууль зүйн догматик арга нь Үндсэн хууль болон холбогдох хуулийн зохицуулалтын агуулга, логик, уялдааг шалгах боломж олгосон бол харьцуулсан арга нь Европын орнуудын парламентын хариуцлагын тогтолцоотой харьцуулан Монголын зохицуулалтын онцлог, цоорхойг тодорхойлоход чиглэгджээ. Түүхэн арга нь парламентын дархан эрх, эгүүлэн татах үзэл баримтлалын үүсэл, хөгжлийн шалтгааныг тайлбарлахад хэрэглэгдсэн бөгөөд кейсийн шинжилгээ нь шүүхээс гэм буруутай гэж тогтоосон гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох үйл явцын практик хүндрэл, зөрчлийг бодитоор тодорхойлох боломжийг олгосон болно.

3. Судалгааны үр дүн

Ард түмэн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах, нийгмийн хэв журмыг хангуулах зэрэг нэгдмэл зорилгынхоо дагуу өөрсдийн эрх чөлөөний тодорхой хэсгийг бүрэн эрхт этгээдэд шилжүүлдэг.³ Тийм ч учир ард иргэд өөрсдийн сонгож байгуулсан парламентад, түүний гишүүдэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх боломжтой байх нь зүй ёсны хэрэг юм. Учир нь төрийн байгууллага, албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглаж хүмүүсийг үл хүндэтгэж, эрх, эрх чөлөөг нь зөрчих эрсдэл ямагт байдаг.⁴ Иймээс улс орнууд парламентын гишүүд нь гэмт хэрэг үйлдсэн бол түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, эрүүгийн болон улс төрийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг Үндсэн хуульдаа тусгаж ирсэн. Монгол Улс 1992 оны ардчилсан Үндсэн хуульдаа гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүнийг эгүүлэн татахаар хуульчилсан нь парламентын гишүүний хариуцлагыг дээшлүүлсэн явдал юм.

Үндсэн хуулийн үзэл баримтлал бол бусад хуулийг зөв боловсруулж, ойлгож, хэрэглэхийн анхдагч түлхүүр⁵ болохын хувьд ердийн хууль тогтоомж нь Үндсэн хуульдаа нийцэж, түүнтэй зөрчилдөхгүй байх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “... гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж заасан. Энэ нь шүүх парламентын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэнийг эцэслэн тогтоосон тохиолдолд түүнийг ямар нэгэн эргэлзээгүйгээр эгүүлэн татахаар тодорхой зохицуулсан заалт юм.⁶ 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх явцад Б.Чимид багш тус заалтын агуулгыг “... шүүхийн шийдвэрээр тогтоогоод дараа нь парламент авч үзнэ гэвэл буруу болно. Яагаад гэвэл шүүхээр тогтоосныг парламент хүчингүй болгох эрх

³ Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2020, 122 дахь тал.

⁴ О.Мөнхсайхан, Хууль дээдлэх ёс: Ерөнхий хандлага ба Монгол, Эрх зүй сэтгүүл, 2020. №4, 5 дахь тал.

⁵ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил), УБ., 2006, 60 дахь тал.

⁶ Г.Агар-Эрдэнэ, Д.Энхбат, Парламентын дархлаа, УБ., 2025, 87 дахь тал.

байхгүй. Шууд автоматаар зөвшөөрч байхаас өөр арга байхгүй ...”⁷ хэмээн тайлбарлаж байв.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурал (УИХ)-ын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно⁸ гэж зааснаар эгүүлэн татах эсэх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг УИХ-д олгожээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн гишүүнийг заавал эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг ердийн хуулиар нарийвчлан зохицуулахдаа санал хураах замаар эгүүлэн татахаар зохицуулжээ. Энэ тохиолдолд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг эгүүлэн татахыг дэмжээгүй бол гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүн эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх, шүүхийн шийдвэр биелэгдэх боломжгүй болох, улмаар Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ ...” гэж заасныг зөрчих нөхцөл бүрдсэн.

Иймд энэхүү илтгэлээр гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүнийг эгүүлэн татахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулах оролдлогыг хийлээ. Мөн илтгэлийг хууль зүйн шинжлэх ухааны аргууд болох түүхчлэх, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон боловсруулалт хийх аргуудыг ашигласан болно.

I. Онолын үзэл баримтлал

2.1. Гэмт хэрэг үйлдсэн парламентын гишүүнийг эгүүлэн татах тухай ойлголт, хандлага

Гэмт хэрэг үйлдсэн парламентын гишүүнийг эгүүлэн татах нь латин хэлний “infamia” буюу “нэр хүндээ алдах” гэх үгнээс гаралтай ойлголт юм. Энэ нь эртний Ромын нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээд тухайн үйлдэлдээ хариуцлага хүлээхээс гадна нэр хүндээ алдах, тодорхой эрхийн хязгаарлалтад орох ёстой хэмээн үздэг хариуцлагын хэлбэр⁹ бөгөөд өнөөдөр олон улсад үйлчилж буй парламентын гишүүн нь өөрийн үйлдсэн гэмт үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээхээс гадна улс төрийн хариуцлага болгож гишүүнийхээ бүрэн эрхийг алдах ойлголттой адил байна.

Парламентын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр эгүүлэн татах тухай ойлголт нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим болон парламентын

⁷ Г.Хэрлэн, Монгол төрийн тогтолцоо 1992 оны Үндсэн хуулийн хэлэлцүүлэг: Төрийн байгуулал, (Хоёрдугаар дэвтэр), УБ., 2020, 180 дахь тал.

⁸ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг. 2024.

⁹ Allars Apsitis, Osvalds Joksts, *The Concept Of Infamy (Infamia) In Roman Law: An Engine For Sustainable Development And Public Security – The Roman Example*, *Journal of Security and Sustainability Issues*, 2013 Volume 3(1), 32 дахь тал.

гишүүний дархан эрхийн ойлголттой салшгүй холбоотой юм. Аливаа хүн гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага заавал хүлээх бөгөөд энэ тухай доктор С.Жанцан “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим нь гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завиш явдал гаргуулахгүй байх ... нөхцөлийг бүрдүүлэхэд үйлчилнэ” гээд “Гэмт хэрэг үйлдсэн хүн бүр заавал хариуцлага хүлээдэг байх нь эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн ач холбогдлыг илэрхийлэх гол арга болдог”¹⁰ хэмээн онож бичжээ.

Мөн парламентын гишүүн нь ард түмний төлөөллийг хэрэгжүүлэгч болохын хувьд бүрэн эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай халдашгүй байдал эдэлдэг. Энэхүү халдашгүй байдал (дархлаа) нь гишүүний бүрэн эрхийг хангах хууль зүйн баталгааны нэг, хамгаалах онцгой хэрэглүүр¹¹ учир түүнийг эрүүгийн хариуцлагад татахад бусад хүмүүсээс ялгаатай байдлыг бий болгодог байна. Учир юу гэвээс ихэнх улсын парламентын гишүүд бүрэн эрхээ¹² хэрэгжүүлэх явцад өгсөн санал, илэрхийлсэн үзэл бодлынхоо төлөө хариуцлага хүлээхгүй байх (Non-accountability), бусад үйлдлийн хувьд харьяалагдах танхимын зөвшөөрөлгүйгээр баривчлагдах, эрүүгийн хэрэг үүсгэхээс хориглох (Inviolability) гэсэн давхар хамгаалалтыг эдэлдэг.¹³ “Inviolability” буюу гишүүний халдашгүй байдал гэдэгт парламентын гишүүний үйл ажиллагааны шууд хүрэнээс гадуур хуулийн хариуцлага хүлээлгэх, баривчлах, цагдан хорих, мөрдөн байцаах болон эрүүгийн хэрэгт татагдахаас хамгаалах эрхийг¹⁴ ойлгох бөгөөд энэ нь парламентын гишүүнийг парламентын зөвшөөрөлгүйгээр баривчлах, яллахаас хамгаалдаг эрх юм. Тийм ч учир парламентын гишүүн гэмт хэрэг үйлдсэн бол халдашгүй байдлыг нь парламентаар дуусгавар болгохгүйгээр түүний эрх чөлөөнд нь шууд халдаж болдоггүй.

Парламентын гишүүдэд халдашгүй байдал олгох санаа эртний Ромоос үүсэлтэй гэж үздэг. Эртний Ромын түшмэлүүд (трибунууд)¹⁵ албан үүргээ чөлөөтэй гүйцэтгэхийн тулд онцгой хамгаалалтыг эдэлдэг байсан бөгөөд тус хоригийг зөрчсөн этгээдэд цаазаар авах хүртэл шийтгэл оноодог байсан аж.¹⁶ Хэдийгээр өнөөгийн нийгэмд дархан эрхийн хүрээнд улс орнууд ийм арга хэмжээ авахаа больсон ч ард түмнээс сонгогдсон төлөөлөгчид нэг талаас албан тушаалын нэр хүнд, ач холбогдлыг тодотгох, нөгөө талаас

¹⁰ С.Жанцан, *Гэмт хэргийн тухай сургаал*, 38 дахь тал.

¹¹ Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг*, УБ., 2008, 214 дэх тал.

¹² *Монгол Улсын Үндсэн хууль дахь УИХ-ын гишүүний бүрэн эрх гэх нэр томъёог УИХ-ын гишүүнээр ажиллах хугацаандаа эдлэх эрх мэдэл гэж ойлгож болно.* (Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, УБ., 2019, 234 дэх тал.)

¹³ S.Hardt, *Parliamentary immunity: a comprehensive study of the systems of parliamentary immunity of the United Kingdom, France, and the Netherlands in a European context*, 2013, 4 дэх тал. <https://cris.maastrichtuniversity.nl/ws/portalfiles/portal/1439730/guid-55b44d63-b482-4e81-b66e-cfc1a4cef467-ASSET1.0.pdf>

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ *Трибунууд гэдэг нь Ромд ихэд дээдлэгддэг байсан, ард түмний эрх ашгийг өмгөөлөн хамгаалагч илтгэгчид юм.* (Жан Жак Руссо, *Нийгмийн гэрээ буюу улс төрийн эрхийн зарчмууд*, Орч. Ц.Батбуян, Ред. Н.Жавхлан, УБ., 2016, 133 дахь тал. “Монсудар” хэвлэлийн газар.)

¹⁶ *Rules on Parliamentary Immunity in the European Parliament and the Member States of the European Union*, 1 дэх тал. <https://discuss.tp4.ir/uploads/short-url/s12OB02Q79mOKPgs96y5PDiBtd.pdf>

бүрэн эрхээ ямар нэгэн саадгүй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх баталгаагаар хангагдсан байх ёстой гэх дээрхтэй ижил үзэл баримтлал оршсон хэвээр байна.¹⁷

Өдгөө ихэнх улсад парламентын гишүүн гэмт хэрэг үйлдсэн бол түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгодог байна. Энэ нь парламентын гишүүн гэмт хэрэг үйлдсэн ч хариуцлага хүлээхгүй байх нь парламентын гишүүний дархан эрхийн зорилго биш байдагтай¹⁸ холбоотой юм.

Монгол Улс 1914 онд “улс төрийн аливаа хүнд чухал хэргийг бүгдээр нийлж шүүмжлэн хэлэлцэж, олны бодлогыг нийлүүлэх” зорилго бүхий Улсын дээд, доод хурлыг байгуулсан нь парламентат ёсыг үүсгэхийг оролдсон анхны эхлэл гэж үздэг.¹⁹ Тухайн цаг үед бичигдсэн “Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг”²⁰, Ж.Цэвээний “Улсын эрх”²¹ бүтээлд гэмт хэрэг үйлдэж ял оногдуулсан гишүүдийг эгүүлэн татахаар зохицуулсан буйгаас үзвэл энэхүү ойлголт нь тухайн цаг үеэс Монгол Улсад анхлан нэвтэрсэн хэмээн дүгнэж болох юм.

Олон улсад парламентын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд түүнийг эгүүлэн татах үндсэн 3 хандлага бий.²² Үүнд:

(1) Парламентын гишүүний бүрэн эрх шүүхийн шийдвэр гарсан цагаас эхлэн дуусгавар болох. Энэ хандлагыг хэрэгжүүлдэг улс оронд шүүхийн шийдвэр гарсан цагаас гишүүнийг эгүүлэн татсанд тооцдог байна. Латви улсын Сэймийн дүрмийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Сэймийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тухайн өдрөөс эхлэн бүрэн эрхээ алдсанд тооцно”²³ гэж заажээ. Мөн Швед улсад шүүх эрх мэдлийн байгууллага нь парламентын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосны дагуу түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд илт тохирохгүй гэж үзвэл эгүүлэн татах эрхтэй байдаг.²⁴

¹⁷ Marc Van der Hulst, *The Parliamentary Mandate A Global Comparative Study*, Inter-Parliamentary Union Geneva 2000, 63 дахь тал. http://archive.ipu.org/pdf/publications/mandate_e.pdf

¹⁸ Inter-Parliamentary Union, *Freedom Of Expression, M Of Expression, Parliament And The Promotion Of Tolerant Societies The Promotion Of Tolerant Societies*, 2006, 15 дахь тал. <https://www.ipu.org/resources/publications/reports/2016-07/freedom-expression-parliament-and-promotion-tolerant-societies>

¹⁹ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, *Монгол Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл, харьцуулсан судалгаа 1914-2013 он)*, УБ., 2013, 33 дахь тал.

²⁰ Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн Есдүгээр дэвтэр, Түшмэлийн засаг Гуравдугаар хэсэгт “Аливаа түшмэл үгүйд ял хийж түшмэл болсны хойно хэрэг гарваас хийсэн нь албаны ял болбоос ташуур занчих ялаас дээш цөм цаазын бичгийн ёсоор зориул. Бага түшмэлд ял хийж түшмэл улсрсны хойно хэрэг гарах ба тушаалд бүхийд ял хийж тушаалаас хөвхорсны хойно хэрэг гарах болбоос албаны ялыг ташуур занчих ялаас доош цаазын бичгийн ёсоор зэрэг бууруул. Пунлүү хас. Зуун ташуурын ялаас дээш цаазын бичгийн ёсоор шүүн оноо...” гэж заажээ.

²¹ “Хэрэв хурлын хүмүүн хуралдааны цагт хууль цааз лугаа зөрчин явбаас гэмт хүмүүнийг энгийн хүмүүний адил барьцаан авч үл болно. Урьдаар хэрэг учралыг харьяат хуралд айлтгаж, хурал зөвшөөрбөөс сая барьж шийтгэж болно. Хурал эс зөвшөөрбөөс барьж үл болмуй” гэж заажээ.

²² Kamil Baranik, *European Parliament, Termination of the mandate of the Member of European Parliament*, 2025, 9 дэх тал.

[https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/767204/EPRS_BRI\(2025\)767204_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/767204/EPRS_BRI(2025)767204_EN.pdf)

²³ Rules of procedure of The Saeima, Article 18(1), 1994. <https://www.saeima.lv/en/legislative-process/rules-of-procedure>

²⁴ Constitution of Sweden, 1974 (rev. 2012), Chapter. 4, Article 11.

https://www.constituteproject.org/constitution/Sweden_2012

(2) Парламентын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг эрх бүхий байгууллага хэлэлцэн шийдвэрлэх. Ихэнх улсад парламентын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг парламент нь шийдвэрлэдэг бол зарим улсад Үндсэн хуулийн шүүх ийм эрхийг эдэлдэг.²⁵ Гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон парламентын гишүүнийг эгүүлэн татахдаа дийлэнх тохиолдолд парламент тухайн асуудлыг чуулганаараа авч хэлэлцэх жишиг олон улсад тогтсон бөгөөд ийнхүү асуудлыг хэлэлцэж байгаа нь дараах шалтгаантай гэж тайлбарладаг.²⁶ Үүнд:

(1) хувь гишүүний асуудал бус нийт парламентын дархлаа хөндөгдөж буй тул тухайн гишүүнийхээ зан байдлын талаар парламент хэлэлцэх эрхтэй байдаг. Үүнд шүүхийн шийдвэртэй холбоотойгоор тухайн гишүүнийг албан тушаалдаа тэнцэх эсэхийг өргөн хүрээнд хэлэлцэж, шийдвэр гаргахдаа үндэслэдэг.

(2) нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалахтай холбоотой бөгөөд сонгогдсон төлөөлөгч нь ямар гэмт хэрэг үйлдсэнийг олон нийтэд мэдүүлэх зорилготой байдаг. Энэ нь парламентын хэлэлцүүлэг ил тод, нээлттэй, “шилэн” байх зарчимтай уялдадаг.

(3) парламентын автономит буюу бие даасан байдалтай холбоотой ба энэ нь шүүхийн шийдвэрийг хэлэлцэж буй асуудал биш, харин парламентын бие даасан байдлыг хангах зарчмын хүрээнд асуудлыг авч хэлэлцэхэд оршдог. Ийнхүү хэлэлцсэнээр парламент шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож чадахгүй нь тодорхой тул шүүхийн шийдвэрийг зөвхөн өөрийн бие даасан үйл ажиллагааныхаа нэг хэсэг болгон ашиглаж буй хэлбэр гэж үздэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна гэж зааснаас үзвэл энэхүү хандлагыг төлөвшүүлсэн болох нь харагдаж байна. Эрх бүхий байгууллага буюу парламент шийдвэр гаргах замаар гишүүнийг эгүүлэн татах нь парламентын бие даасан байдлыг бататгах давуу талтай ч хэлэлцүүлгийн хугацаанаас хамаарч эгүүлэн татахад урт хугацаа орох сөрөг үр дагавартай байна.

(3) Гэмт хэрэг үйлдсэн нь парламентын гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэл болохгүй тохиолдол. Парламентын гишүүн нь маш өргөн халдашгүй байдал эдэлж байгаа тохиолдолд энэ нь боломжтой бөгөөд энэ хандлагыг хэрэгжүүлдэг улс маш ховор байна. Гэхдээ зарим улсад парламентын гишүүнийг эгүүлэн татахын тулд үйлдсэн гэмт хэрэгт нь шалгуур тогтоодог бөгөөд энэ тохиолдолд энэхүү хандлагын улсууд нь дээрх хоёр хандлагын улсуудтай давхцах боломжтой. Зарим улсад болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, эсвэл хорихоос өөр төрлийн ял оногдуулсан тохиолдолд эгүүлэн татдаггүй байна. Тухайлбал, Болгар улсын парламентын гишүүн санаатай гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдвол түүнийг парламентын шийдвэрээр

²⁵ Герман, Унгар, Словени улсад парламентаас шийдвэр гарах ёстой байдаг бол Бүгд Найрамдах Франц Улс болон Португал улсад Үндсэн хуулийн шүүх нь парламентын гишүүнийг эгүүлэн татах эрхтэй байна.

²⁶ Г.Агар-Эрдэнэ, Д.Энхбат, Парламентын дархлаа, УБ., 2025, 87-88 дахь тал.

эгүүлэн татах эрх зүйн зохицуулалттай.²⁷ Харин Канад улсад парламентын гишүүн нь хоёр ба түүнээс дээш жил хорих ял оногдуулсан гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдвол түүнийг эгүүлэн татдаг байна.²⁸

Судлаачийн зүгээс дээрх гурван хандлагын давуу болон сул талуудыг ийнхүү авч үзэв.

	<i>Парламентын гишүүний бүрэн эрх шүүхийн шийдвэр гарсан даруйд дуусгавар болох</i>	<i>Парламентын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг эрх бүхий байгууллага хэлэлцэн шийдвэрлэх</i>	<i>Парламентын гишүүн гэмт хэрэг үйлдсэн ч бүрэн эрх нь дуусгавар болохгүй тохиолдол</i>
Давуу тал	- Сонгох, сонгогдох эрх хангагдах; - Шударга ёс, хууль дээдлэх ёс бэхжих; - Хууль шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх зарчим хангагдах;	- Парламентын бие даасан байдлыг хангах;	- Парламентын бие даасан, хараат бус байдал хангагдах;
Сул тал	- Парламентын бие даасан байдал сулрах; - Шүүхийн шийдвэр улс төржих эрсдэлтэй;	- Парламент нь гишүүнээ хамгаалах (улс төржих) эрсдэлтэй; - Цаг хугацаа алдах буюу нөхөн сонгууль явагдах хугацаа хойшлох;	- Иргэдийн шүүх, төрд итгэх итгэл буурах; - Хууль тогтоох байгууллагын нэр хүнд унах; - Шударга ёс, хууль дээдлэх ёс алдагдах;

Эх сурвалж: Зохиогч боловсруулсан болно.

II. Асуудал дэвшүүлэх нь

Монгол Улсад УИХ-ын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд гэмт хэрэг үйлдсэн бөгөөд шүүхийн шийдвэрээр түүнийг гэм буруутай болохыг тогтоосны дараа УИХ түүнийг эгүүлэн татсан тохиолдол өмнө нь гарч байгаагүй юм.²⁹ Харин 2024 онд нэр бүхий УИХ-ын гишүүн Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт³⁰ заасан гэмт хэрэг үйлдсэн болох нь Улсын Дээд шүүхийн шийдвэрээр тогтоогдсоноор түүнийг гишүүнээс нь эгүүлэн татах үндэслэл бүрдсэн. Тус гишүүн өнөөдрийг хүртэл хугацаанд

²⁷ *The Constitution of the Republic of Bulgaria, 2003, Article 72(1).*
<https://constitutionnet.org/sites/default/files/Bulgaria%20Constitution.pdf>

²⁸ *Criminal code, Article 750, 1985.*

²⁹ *Хавсралт хэсгээс дэлгэрэнгүй харна уу.*

³⁰ “Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан.

(2025.09.10) УИХ-ын гишүүний ажлаа хийсээр байгаа нь Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүн эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, төрийн өндөр албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй гэх яриа иргэдийн дунд гарахад хүргэж байна.

УИХ гишүүнийг эгүүлэн татахгүй байгаа нь үндсэн хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, шүүхийн шийдвэр гарсны дараа УИХ гишүүнийг эгүүлэн татах асуудлыг УИХ хэлэлцэж санал хураахаар зохицуулсан нь Үндсэн хуульд нийцэх эсэх асуудал, хоёрдугаарт, шүүхийн шийдвэр гарсны дараа УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах журмыг тодорхой хуульчлаагүй асуудал болно. Эдгээр асуудал тус бүрийг дор авч үзье.

1. Гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцэж, санал хураахаар зохицуулсан нь Үндсэн хуульд нийцэх эсэх асуудлын тухайд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “... гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж заасан. Энэ нь шүүх парламентын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэнийг эцэслэн тогтоосон тохиолдолд түүнийг ямар нэгэн эргэлзээгүйгээр эгүүлэн татахаар тодорхой зохицуулсан заалт юм.³¹ 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх явцад Б.Чимид багш тус заалтын агуулгыг “... шүүхийн шийдвэрээр тогтоогоод дараа нь парламент авч үзнэ гэвэл буруу болно. Яагаад гэвэл шүүхээр тогтоосныг парламент хүчингүй болгох эрх байхгүй. Шууд автоматаар зөвшөөрч байхаас өөр арга байхгүй ...”³² хэмээн тайлбарлаж байв.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуульд УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно³³ гэж зааснаар эгүүлэн татах эсэх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг УИХ-д олгожээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн гишүүнийг заавал эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг ердийн хуулиар нарийвчлан зохицуулахдаа санал хураах замаар эгүүлэн татахаар зохицуулжээ. Энэ тохиолдолд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг эгүүлэн татахыг дэмжээгүй бол гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүн эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх, шүүхийн шийдвэр биелэгдэх боломжгүй болох, улмаар Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ ...” гэж заасныг зөрчжээ.

“Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх” гэдэг нь түүний эрх зүйн маргаан шийдсэн шийдвэртэй цаашид маргах бололцоогүй, харин тэр нь хуультай харшилбал зөвхөн Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох нөхцөлтэй байхыг

³¹ Г.Агар-Эрдэнэ, Д.Энхбат, *Парламентын дархлаа*, УБ., 2025, 87 дахь тал.

³² Г.Хэрлэн, *Монгол төрийн тогтолцоо 1992 оны Үндсэн хуулийн хэлэлцүүлэг: Төрийн байгуулал, (Хоёрдугаар дэвтэр)*, УБ., 2020, 180 дахь тал.

³³ *Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг*. 2024.

ойлгодог.³⁴ Мөн түүнийг өөр этгээд өөрчлөх, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, түүнийг биелүүлэх үйл ажиллагааг саатуулах, хойшлуулах эрхгүй байхыг ойлгох юм.³⁵ Харин дээрх тохиолдолд шүүхийн шийдвэр биелэгдэхгүй болсон нь Үндсэн хуулийн эл заалт зөрчигдөж байгааг харуулж байна.

Нөгөө талаас УИХ-ын үйл ажиллагаа нь цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэх³⁶ бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэдэг.³⁷ Харин дээрх асуудлыг санал хураахгүйгээр, мөн УИХ-ын шийдвэр гаргах ажиллагааны зарчмыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэх боломж байгаа эсэхийг судлах шаардлагатай юм. УИХ-ын энэхүү шийдвэр гаргах ажиллагааны зарчим нь тодорхой тохиолдолд хамаардаггүй. Тухайлбал, УИХ-ын гишүүн Ерөнхийлөгчөөр сонгогдсон болон нас барсан тохиолдолд орон гарсан гэж үзэж энэ тухай УИХ-аас шийдвэр гаргадаггүй³⁸ бол зарим тохиолдолд УИХ тодорхой асуудлыг хэлэлцүүлэггүйгээр санал хураах³⁹ боломжтой байдаг. УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг УИХ санал хуралтын журмаар шийдвэрлэхгүй байх боломж нь танхимын дарга шийдвэр гаргах юм. Энэтхэг улсад гэмт хэрэг үйлдсэн гишүүнийг парламентын шийдвэрээр эгүүлэн татах ёстой боловч энэ талаар санал хураадаггүй. Учир нь парламентын дарга нь тухайн асуудлыг парламентад танилцуулан сонгосноор гишүүний суудал чөлөөлөгдсөнд тооцдог байна. Харин шийдвэрлэх журмын хувьд, УИХ-ын дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий УИХ-ын даргын зөвлөл эхлээд хэлэлцэж, дараа нь УИХ-ын дарга шийдвэр гаргах боломжтой.

2. УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах журмыг тодорхой хуульчлаагүй асуудлын тухайд:

Парламентын үйл ажиллагааны журам буюу дэг нь аливаа хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны гол үндэс бөгөөд парламентын үйл ажиллагааг нэг бүрчилсэн тодорхой заалтуудаас бүрддэг.⁴⁰ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд УИХ-ын гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгохтой холбоотой асуудлыг хэлэлцэх журмыг зохицуулсан боловч гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах асуудалд ямар журам баримтлах талаар зохицуулалт байхгүй. Иймд дээрх асуудлыг хуульчлан зохицуулаагүйгээс эрх зүйн үйлчлэл дутаж хийдэл⁴¹ үүссэн тул энэ талаарх асуудлыг хуульчлах шаардлага үүсжээ.

³⁴ Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар*, УБ., 2022, 826 дахь тал.

³⁵ Мөн тэнд. 827 дахь тал.

³⁶ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг. 2024.

³⁷ Мөн тэнд. 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг.

³⁸ Мөн тэнд. 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг.

³⁹ Мөн тэнд. 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг.

⁴⁰ Л.Өлзийсайхан, *Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс*, УБ., 2010, 42 дахь тал.

⁴¹ Эрх зүйн хийдэл гэдэг нь ... хууль, түүний хэм хэмжээнүүдээр шууд зохицуулагдах харилцаа нь хуульчлагдаж чадаагүйгээс эрх зүйн үйлчлэл дутагдаж, үр дагавар бий болгосон хууль зүйн онцгой нөхцөл байдал мөн. (Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, УБ., 2018, 5 дахь хэвлэл, 191 дэх тал.)

УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах журмыг хуульчилсан олон тооны хууль хүчин төгөлдөр үйлчилж байснаас 2001 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсны дараа УИХ гишүүнийг эгүүлэн татах хугацааг тодорхой заасан байв. Тодруулбал, тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 15 хоног, хэрэв энэ хугацаанд хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан бол хяналтын шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш **15 хоногийн дотор Улсын Их Хурал түүнийг эгүүлэн татах тухай шийдвэр гаргана**. Энэ шийдвэрийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо санаачлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Уг шийдвэрийн төслийг Хууль зүйн байнгын хороо заавал хянан хэлэлцэж зохих дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулна.” гэж заажээ. Хэрэв гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн шүүхийн шийдвэр нь Улсын Их Хурлын ээлжит чуулган завсарласан үед хүчин төгөлдөр болсон тохиолдолд уг асуудлыг хэлэлцүүлэхээр ээлжит бус чуулган зарлан хуралдуулахаар заасан⁴² зэргээс үзвэл тухайн харилцааг зохицуулсан журмыг тодорхой зохицуулсан байв. Мөн 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд “Шүүх Улсын Их Хурлын гишүүнтэй холбогдсон хэргийн талаар гаргасан шийдвэрээ нэн даруй Улсын Их Хуралд илгээнэ”⁴³ гэж зааснаар шүүхийн шийдвэрийг УИХ-д илгээх тодорхой журмыг хуульчилсан байв. Харин түүнээс хойш хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулиудад энэ талаар зохицуулаагүй нь эрх зүйн хийдэл бий болгосон гэж дүгнэх үндэстэй.

УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах журмыг тодорхой хуульчлаагүйгээс гэмт хэрэг үйлдсэн гишүүн эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх, иргэдийн төрд итгэх итгэл алдагдах, улмаар шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх, нөхөн сонгууль⁴⁴ явагдах хугацаа хойшлох зэрэг олон сөрөг үр дагаврыг авчирна. Төрийн үйл хэрэг тасралтгүй, тогтвортой явагдах нь парламентын ардчилсан улсын парламентын тулгуур зарчим мөн тул УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусаж, орон гарсан бол дараагийн гишүүнийг сонгох нөхөн сонгууль явагдана. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлд гэмт хэрэг үйлдсэн УИХ-ын гишүүнийг эгүүлэн татахаар зааж, УИХ-ын гишүүн ард түмнээс эх сурвалжтай бөгөөд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагаа халагдах, солигдох ёстой байх ардчилсан ёсны зарчмыг⁴⁵ баталгаажуулжээ. Дээрх асуудлаас үүдэн дараагийн гишүүнийг нөхөн сонгох хугацаа удааширч, иргэдийн сонгуулийн эрхэд сөргөөр нөлөөлөх болсон.

Парламентын үйл ажиллагааны дэгээр бүхий л асуудлыг зохицуулах боломжгүй гэж үздэг бөгөөд тусгайлан зохицуулаагүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар авч үзэх

⁴² Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг. 2001.

⁴³ Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэг. 1997.

⁴⁴ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан, мөн энэ хуулийн 77.1-д заасны дагуу сонгогдсонд тооцох дараагийн нэр дэвшигч үлдээгүй бол нөхөн сонгууль явагдана.” гэж заасан. 2019.

⁴⁵ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар, УБ., 2022, 364 дэх тал.

шаардлагатай. Энэ тохиолдолд юуны өмнө парламентын даргад байнгын буюу онцгой тохиолдолд дэгд асуудлыг шийдвэрлэхээр өөрчлөлт оруулах эрх олгох замаар тулгарсан асуудлыг шийдвэрлэх боломжтой⁴⁶ гэж судлаачид үздэг. Өөрөөр хэлбэл дэгээр зохицуулаагүй асуудлыг парламентын дарга хуульд нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

III. Харьцуулсан судалгаа

4.1. Бүгд Найрамдах Франц Улсын эрх зүйн зохицуулалт

Парламентын гишүүний халдашгүй байдлын онол, үзэл санаа анх бүрэлдэн бий болсон Бүгд Найрамдах Франц Улсын парламентын гишүүний бүрэн эрхийг эгүүлэн татахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг судалсан. Тус улсыг судалснаар парламентын гишүүний халдашгүй байдлын онол номлол Монгол Улсын эрх зүйд бодитой тусгагдсан эсэхийг тодруулахад ач холбогдолтой гэж үзсэн болно.

Бүгд Найрамдах Франц улсын парламент (хууль тогтоох институт) нь Үндэсний Ассамблей, Сенатаас бүрдэнэ. Үндэсний Ассамблейн гишүүдийг ард түмэн чөлөөтэй, шууд сонгуулиар сонгож байгуулдаг бол Сенатын гишүүдийг Сонгуулийн Коллеги зохион байгуулдаг буюу коллегийн гишүүдийн дунд санал хураалт явуулж шууд бус сонгуулиар сонгодог.⁴⁷ Парламентын гишүүнийг эгүүлэн татахтай холбоотой харилцааг Үндсэн хууль⁴⁸, Сонгуулийн тухай хууль⁴⁹, Үндэсний ассамблейн дүрэм⁵⁰, Конгрессын дүрэм⁵¹, Үндэсний Ассамблейн Товчооны дүрэм⁵², Үндэсний Ассамблейн чуулганы хуралдааны дэгийн тухай⁵³ хуулиар тус тус зохицуулж байна.

Франц улсын парламентын гишүүн сонгуулийн гэмт хэрэг үйлдсэн бол Үндсэн хуулийн шүүхээс түүнийг эгүүлэн татдаг. Ингэхдээ Хууль зүйн сайдын хүсэлтээр, эсвэл ял оногдуулсан прокурор хүсэлт гаргаж болно.⁵⁴ Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц парламентын гишүүний бүрэн эрх дуусгавар болдоггүй бөгөөд парламентын хүсэлтээр Үндсэн хуулийн Зөвлөл гишүүнийг эгүүлэн татах эрхтэй байна. Сонгуулийн тухай хуулийн LO136 дугаар зүйлд “Сонгуулийн дүнг зарласны дараа болон маргаан хэлэлцэх хугацаа дууссаны дараа парламентын гишүүн сонгогдох эрхгүй болох нь тогтоогдсон, эсхүл бүрэн эрхийнхээ хугацаанд энэхүү хуульд заасан эрхгүй болох нөхцөлүүдийн аль нэгэнд хамаарагдах нь тогтоогдсон бол Үндэсний Ассамблейн дарга,

⁴⁶ Л.Өлзийсайхан, *Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс*, УБ., 2010, 47 дахь тал.

⁴⁷ Ч.Энхбаатар, С.Зульфикар, *Гадаад орнуудын төрийн байгуулалт*, УБ., 2014, 122 дахь тал.

⁴⁸ *Constitution of France*, 1958.

https://www.conseil-constitutionnel.fr/sites/default/files/as/root/bank_mm/anglais/constitution_anglais_oct2009.pdf

⁴⁹ *Code électoral*, https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070239/

⁵⁰ *Règlement de l'Assemblée nationale*, https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/02_reglement_assemblee_nationale

⁵¹ *Règlement du Congrès du Parlement*, 1963, https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/03_reglement_du_congres

⁵² *Instruction générale du Bureau*, 1959, https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/04_instruction_generale_bureau

⁵³ *Sur le règlement intérieur de la session de l'Assemblée nationale*, 2002. <https://ceracle.com/wp-content/uploads/2020/08/R%C3%A8glement-interieur-de-lAssembl%C3%A9e-nationale-du-S%C3%A9n%C3%A9gal-texte-consolid%C3%A9.pdf>

⁵⁴ *Venice Commission, Report on Exclusion of Offenders from Parliament*, CDL-AD(2015)036cor, 2015, 24 дэх тал. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2015\)036cor-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2015)036cor-e)

Хууль зүйн сайд, ял оногдуулсан прокуророос гаргасан хүсэлтийг үндэслэн Үндсэн хуулийн Зөвлөл гишүүнийг эгүүлэн татна.” гэж заасан.

4.2. Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалт

Бүгд Найрамдах Солонгос Улс нь парламентын гишүүнд хариуцлага тооцох тал дээр сайн жишиг тогтоосон улсын нэгд зүй ёсоор тооцогддог тул тус улсын эрх зүйн зохицуулалтыг судлах нь зүйтэй гэж үзсэн болно. Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх)-ын парламент нь нэг танхим бүхий Үндэсний Ассамблей юм. Үндэсний Ассамблейн гишүүний эрх зүйн байдлыг БНСУ-ын Үндсэн хууль⁵⁵, Үндэсний Ассамблейн тухай хууль⁵⁶, Үндэсний Ассамблейн дүрмээр тус тус зохицуулж байна.

Гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд парламентын гишүүний бүрэн эрх шууд дуусгавар болдог бөгөөд энэ асуудлыг парламентаар хэлэлцдэггүй. Төрийн албан хаагчийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр болон бусад актаар эрхээ хасуулсан, эсхүл эрх нь түдгэлзсэн этгээдийг төрийн албанд ажиллуулахыг хориглоно” гэж заасан.

Гэмт хэрэг үйлдсэн парламентын гишүүнийг парламентаар хэлэлцэн түүнийг эгүүлэн татах ёстой эсэх талаар шийдвэрлэсэн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг энд авч үзье.

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2011 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 476 дугаартай шийдвэр.⁵⁷

Маргааны агуулга:

Үндэсний Ассамблейн гишүүн А нь 2008 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн сонгуулиар сонгогдсон. Улсын дээд шүүхийн шийдвэрээр⁵⁸ түүнийг сонгуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоож, Үндэсний Ассамблейн гишүүнээр сонгогдсоныг хүчингүйд тооцож, сонгуулийн зардал буцаан олгуулах, 5 жилийн хугацаанд сонгогдох эрхээ алдах, 5 жилийн хугацаанд албан тушаал эрхлэх, тодорхой албан тушаалд томилогдохыг хориглож шийдвэрлэсэн байна. Тэрээр Төрийн албаны сонгуулийн тухай хууль, Үндэсний Ассамблейн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн 2009 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Үндсэн хуулийн шүүхэд хандсан.

Гомдол гаргагчийн тайлбар:

⁵⁵ Constitution of The Republic of Korea, 1987.

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1

⁵⁶ National assembly act, 1948.

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁵⁷ 헌법재판소 2011. 12. 29. 선고 2009헌마476 전원재판부 [공직선거법제250조등위헌확인] [헌집23-2, 806],

<https://casenote.kr/%ED%97%8C%EB%B2%95%EC%9E%AC%ED%8C%90%EC%86%8C/2009%ED%97%8C%EB%A7%88476>

⁵⁸ 대법원 2009. 7. 23. 선고 2009도2649 판결 [공직선거법위반],

<https://casenote.kr/%EB%8C%80%EB%B2%95%EC%9B%90/2009%EB%8F%842649>

“... Сонгуулийн дүнг хүчингүй болгох, төрийн алба хаших эрхийг хязгаарлах зэрэг чухал асуудлыг шүүгчийн оногдуулсан ялаас шууд хамааралтай байхаар зохицуулсан нь ардчиллын үндэс суурь болсон сонгуулийн тогтолцооны үр нөлөөг ноцтойгоор хязгаарлаж байна. Мөн парламентын гишүүнийг эгүүлэн татах эсэх нь парламентын бүрэн эрхийн асуудал бөгөөд шүүх эрх мэдэл үүнд нөлөөлөх ёсгүй. Иймд дээрх заалтууд нь парламентын гишүүний эрх зүйн байдлыг шүүх хянахад хүрч, улмаар эрх мэдэл хуваарилалтын зарчимд харшилсан. Мөн Үндэсний Ассамблейн тухай хуульд Үндэсний Ассамблейн гуравны хоёроос доошгүйн саналаар гишүүнийг эгүүлэн татах өндөр босгыг тогтоосон боловч дээр дурдсан хуульд түүний шалгуур босгыг 1 сая вон гэж хэтэрхий доогуур тогтоосон⁵⁹ нь мэдээлэл гаргагчийн тэгш эрх, төрийн алба хаших эрхийг зөрчсөн ...” гэжээ.

Шийдвэрлэсэн байдал:

... Үндэсний Ассамблейн гишүүн нь ард түмний төлөөлөгч бөгөөд хууль тогтоох байгууллагын гишүүн тул хэн хүнээс илүү хууль журмыг чандлан биелүүлэх ёстой. Хууль зөрчиж парламентад сонгогдсон хүн ард түмнийг төлөөлөх буюу тэдний итгэлийг хүлээх боломжгүй гэж үзэх бөгөөд тухайн албан тушаалд шударгаар ажиллах эсэх нь эргэлзээтэй юм. Гэмт хэрэгт оногдуулах хариуцлагыг хуульчлах нь тухайн улсын түүх, соёл, хууль тогтоогдох үеийн нөхцөл байдал, ард иргэдийн нийтлэг ашиг сонирхол, хууль зүйн ухамсар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого зэрэг олон хүчин зүйлийг харгалзан авч үзсэн хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарах асуудал юм. Түүнчлэн манай улсын сонгуулийн түүхэнд ёс суртахуунгүй, хууль бус үйлдлүүд гарч байсанд шүүмжлэлтэй хандаж ирсэн тул ийм хууль бус сонгуулийн орчныг халж, шударга сонгуулийн соёлыг төлөвшүүлэхийн тулд сонгуулийн хууль зөрчсөн үйлдэлд оногдуулах хариуцлагыг чангатгах шаардлага бий. Энэ үндэслэлээр 1 сая воноос дээш хэмжээгээр торгуулийн ял оногдуулсан нь сонгуулийн будилаан тарих эрсдэлийг хязгаарлаж, шударга сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэх боломжтой. Төрийн албаны сонгуулийн тухай хуулийг зөрчиж 1 сая воноос дээш хэмжээний торгох ял шийтгүүлсэн тохиолдолд сонгуулийн дүнг хүчингүй болгох тухай заалт нь шударгаар сонгууль явуулах буюу хууль бус аргаар төрийн алба хаахыг хязгаарлах зорилготой. Энэхүү зорилго нь Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нийтийн ашиг сонирхолд нийцэх учир дээрх заалт нь хууль ёсных, зохистой эрх зүйн зохицуулалт болно. Гэмт хэрэг үйлдэж 1 сая воноор торгох ял шийтгэгдэхээр заасан нь шүүх парламентын гишүүний бүрэн эрхэд халдаж байгаа явдал биш, харин парламент хууль тогтоох эрх мэдлийнхээ дагуу тус шалгуурыг тогтоосон явдал болно.

Нөгөө талаас Төрийн албаны сонгуулийн тухай хууль зөрчиж сонгогдсон гишүүдэд зөвхөн эрүүгийн шийтгэл оногдуулаад өнгөрөөвөл “ямар ч хамаагүй аргаар сонгогдох” хандлагыг төлөвшүүлж, сонгуулийн зөрчил ихсэх үр дагаварт хүргэх боломжтой. Иймд энэ тохиолдолд сонгуулийн дүнг хүчингүй болгох нь хамгийн үр дүнтэй арга байж болно. Мөн энэ заалтаар хувь хүний эрх ашгийг хязгаарлаж байгаа нь

⁵⁹ Төрийн албаны сонгуулийн тухай хуулийн 264 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Сонгуульд нэр дэвшигч нь энэ хууль болон Улс төрийн санхүүжилтийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн, эсхүл 1 сая воноос дээш хэмжээний торгох ял шийтгүүлсэн тохиолдолд түүнийг эгүүлэн татна” гэж заасан.

олон нийтийн ашиг сонирхолтой харьцуулбал түүнээс илүү чухал гэж үзэх боломжгүй тул уг заалт нь “тэнцвэрийн зарчим”-ыг зөрчөөгүй гэж үзнэ. ...”

Ийнхүү гомдол гаргагчийн ирүүлсэн гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Шүүгчийн тусгай санал:

Шүүгч Ким Чен Дэ гомдол гаргагчийн үндсэн эрх зөрчигдсөн, мөн заалтууд нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэн тусгай санал гаргасан. Үүнд:

“ ... Үндэсний Ассамблейн гишүүн нь орчин үеийн ардчиллын тулгуур зарчмын дагуу ард иргэдээс сонгуулийн үндсэн дээр сонгогдсон төлөөлөгч, төрийн үйл хэрэгт шууд оролцох албан тушаалтан тул түүний эрх зүйн байдал нь Үндсэн хуульт байгууллын хувьд онцгой ач холбогдолтой. Үндэсний Ассамблейн гишүүнийг Үндэсний Ассамблейн зөвшөөрөлгүйгээр эгүүлэн татах эрх зүйн зохицуулалт нь ард түмний бүрэн эрхт байдал, ардчиллын зарчмыг хязгаарлаж буй явдал юм. Иймд түүний бүрэн эрхийг дуусгавар болгох талаарх эрх зүйн зохицуулалт нь “тэнцвэрийн зарчим”-ын дагуу гишүүний үндсэн эрхийг зөрчсөн байна.

Харин үүний оронд Үндэсний Ассамблей нь сонгуулийн гэмт хэрэг үйлдэгдэж, шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тухайн шийдвэрт үндэслэн гишүүний улс төрийн эрхийг хязгаарлах эсэхийг шийдвэрлэдэг байж болно. Гэхдээ, хэрэв Үндэсний Ассамблей нь иргэний улс төрийн эрхийг хязгаарлах эсэхийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шийдвэрлэж байхаар хуульчилсан бол мөн хязгаарлалтад тодорхой шалгуур тавигдах ёстой. Шүүхийн шийдвэрийг шударга, хараат бус гэж үзэж болох ч парламентын гишүүний бүрэн эрхийг шийдвэрлэх эрхийг шүүх байгууллагад хадгалах нь зохисгүй. Учир нь Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу үндсэн эрхийг хязгаарлах арга хэрэгсэл нь зохистой, үндэслэлтэй байхыг шаарддаг. Иймд шүүхийн шийдвэрийн гол үндэслэл нь үндсэн эрхийг хязгаарлахад үндэслэлтэй, объектив шалгуур болох ёстой. Энэ тохиолдолд сонгуулийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн улс төрийн эрхийг шүүхийн оногдуулсан 1 сая воноос дээш торгуулийн ялыг үндэслэн шийдвэрлэж байх талаарх заалт нь үндэслэлтэй, зохистой арга биш тул Үндсэн хуулийн зохистой байх шалгуурыг зөрчиж байна. Иймд сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах асуудлыг шүүх шийдвэрлэснээр шүүх байгууллагад хэт их эрх мэдэл олгож буй хэрэг, мөн шүүх улс төрийн зорилгоор шийдвэр гаргаж байна гэх ойлголтыг бий болгох эрсдэлтэй. Шүүхийн үзэмжээр оногдуулсан торгох ял сонгогдсон төлөөлөгчийн үндсэн эрхийг хязгаарлах нь зохисгүй, 1 сая воны торгуулийн хэмжээг заасан нь бодитой, үндэслэлтэй биш юм ...”

Дээрх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс үзэхэд парламентын гишүүнийг эгүүлэн татахад парламентын зөвшөөрөл шаардлагатай эсэх асуудал маргаантай байдаг болох нь харагдаж байна. Мөн гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсан даруйд парламентын гишүүний бүрэн эрх дуусгавар болдог улсад хууль тогтоогчид хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд тухайн зохицуулалтыг боловсруулсан

гэж үздэг.Өөрөөр хэлбэл гишүүнд ял оногдуулах талаарх эрх зүйн зохицуулалт нь парламентын хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд тогтоосон шалгуур хэмээн үзэж байна.

4. Дүгнэлт, санал

Монгол Улсын Үндсэн хуульд УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болохыг шүүх тогтоовол түүнийг заавал эгүүлэн татахаар хуульчилсан. Харин энэхүү харилцааг нарийвчлан зохицуулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд “гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцох”-оор зохицуулсан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалаас гажсан зохицуулалт болжээ. Энэ нь эрх мэдэл хуваарилах онол, эрүүгийн эрх зүйн суурь зарчимтай зөрчилдөж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Парламентын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг чуулганаараа авч хэлэлцэх нь парламентын бие даасан байдлыг бататгах чухал хүчин зүйл болдог. Учир нь энд дан ганц гишүүний асуудал яригддаггүй, нийт парламентын халдашгүй байдал яригддаг. Гэхдээ ийм улсууд шүүхийн шийдвэрийг зөвхөн зарчмын хувьд авч үздэг бөгөөд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчимд нийцүүлэн санал хураалт явуулдаггүй байна.

Мөн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр УИХ-ын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон тохиолдолд уг асуудлыг УИХ хэрхэн хүлээн авч, гишүүнийг эгүүлэн татах журмын зохицуулалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд байхгүйгээс тодорхойгүй байдлыг бий болгож байна. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон талаар парламентад даруй мэдэгдэх, үүнд үндэслэн гишүүнийг эгүүлэн татах эрх зүйн зохицуулалтыг хуульд тодорхой зааснаар хугацаа алдалгүй шүүхийн шийдвэрийг биелүүлэх, нөхөн сонгууль явуулах замаар иргэдийн сонгуулийн эрхийг хангах боломжтой болох нь харагдаж байна.

Иймд УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

2001 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасантай адилаар УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах журмын заалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгах. Жишээ нь, УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон хяналтын шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Улсын Их Хурал түүнийг эгүүлэн татах тухай шийдвэр гаргана. Энэ шийдвэрийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо нэгдсэн хуралдаанд оруулна.

Гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон УИХ-ын гишүүнийг УИХ-ын даргын шийдвэрээр эгүүлэн татаж, УИХ-д сонгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хоёр үндэслэлээр нь ялган шийдвэрлэхээр заах. Ингэхдээ гишүүн гэмт хэрэг

үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд хуралдаанаар хэлэлцэж олонхын дэмжлэг авсан тохиолдолд тогтоол баталсанд тооцох заалтыг тус хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгээс хүчингүй болгож, “Гишүүнийг чөлөөлөх, энэ хуулийн 9.3-т заасан эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, энэ хуулийн 9.1.4, 9.3-т заасан асуудлаар гишүүн саналаа нууцаар, энэ хуулийн 9.1.2, 9.1.3-д заасан асуудлаар гишүүн саналаа илээр гаргана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.” гэж өөрчлөн найруулах.

5. Эх сурвалж

1. Эрх зүйн эх сурвалж

- 1.1. *Монгол Улсын Үндсэн хууль, 1992*
- 1.2. *Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, 1997*
- 1.3. *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019*
- 1.4. *Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2024*
- 1.5. *Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг, 2001*
- 1.6. *Эрүүгийн хууль, 2015*
- 1.7. *Code électorale of France*
- 1.8. *Constitution of The Republic of Korea, 1987*
- 1.9. *Constitution of Sweden, 1974 (rev. 2012)*
- 1.10. *Criminal code of Canada, 1985*
- 1.11. *Instruction générale du Bureau, 1959*
- 1.12. *National assembly act, 1948*
- 1.13. *Règlement de l'Assemblée nationale, 1959*
- 1.14. *Règlement du Congrès du Parlement, 1963*
- 1.15. *Rules of procedure of The Saeima, 1994*
- 1.16. *Sur le règlement intérieur de la session de l'Assemblée nationale, 2002*
- 1.17. *The Constitution of the Republic of Bulgaria, 2003*

2. Монгол хэл дээрх эх сурвалж

- 2.1. *Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил), УБ., 2006*
- 2.2. *Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, УБ., 2008*
- 2.3. *Г.Агар-Эрдэнэ, Д.Энхбат, Парламентын дархлаа, УБ., 2025*
- 2.4. *Г.Хэрлэн, Монгол төрийн тогтолцоо 1992 оны Үндсэн хуулийн хэлэлцүүлэг: Төрийн байгуулал, (Хоёрдугаар дэвтэр), УБ., 2020*
- 2.5. *Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, УБ., 2019*
- 2.6. *Жан Жак Руссо, Нийгмийн гэрээ буюу улс төрийн эрхийн зарчмууд, Орч. Ц.Батбуян, Ред. Н.Жавхлан, УБ., 2016*
- 2.7. *Ж.Цэвээн, Улсын эрх, УБ., 2014*
- 2.8. *Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг, 1914*
- 2.9. *Л.Өлзийсайхан, Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс, УБ., 2010*
- 2.10. *Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл, харьцуулсан судалгаа 1914-2013 он), УБ., 2013*
- 2.11. *Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2020*
- 2.12. *Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар, УБ., 2022, 364 дэх тал.*
- 2.13. *О.Мөнхсайхан, Хууль дээдлэх ёс: Ерөнхий хандлага ба Монгол, Эрх зүй сэтгүүл, 2020, №4.*
- 2.14. *С.Жанцан, Гэмт хэргийн тухай сургаал*

- 2.15. Хөгжлийн банкны гэх 80 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох хэргийн шийдвэрийн тойм,
<https://www.supremecourt.mn/mn/home?page=pages&id=58&pg=3406&pr=14&tp=list&h=0>
- 2.16. Ч.Энхбаатар, С.Зульфикар, Гадаад орнуудын төрийн байгуулалт, УБ., 2014

Гадаад хэл дээрх эх сурвалж

- 3.1. *Inter-Parliamentary Union, FREEDOM OF EXPRESSION, M OF EXPRESSION, PARLIAMENT AND THE PROMOTION OF TOLERANT SOCIETIE THE PROMOTION OF TOLERANT SOCIETIES*, 2006,
<https://www.ipu.org/resources/publications/reports/2016-07/freedom-expression-parliament-and-promotion-tolerant-societies>
- 3.2. *Kamil Baranik, European Parliament, Termination of the mandate of the Member of European Parliament*, 2025,
[https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/767204/EPRS_BRI\(2025\)767204_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/767204/EPRS_BRI(2025)767204_EN.pdf)
- 3.3. *Marc Van der Hulst, THE PARLIAMENTARY MANDATE A GLOBAL COMPARATIVE STUDY*, *Inter-Parliamentary Union Geneva* 2000,
http://archive.ipu.org/pdf/publications/mandate_e.pdf
- 3.4. *Rules on Parliamentary Immunity in the European Parliament and the Member States of the European Union*, <https://discuss.tp4.ir/uploads/short-url/s12OB02Q79mOKPgsd96y5PDiBtd.pdf>
- 3.5. *S.Hardt, Parliamentary immunity : a comprehensive study of the systems of parliamentary immunity of the United Kingdom, France, and the Netherlands in a European context*, 2013, <https://cris.maastrichtuniversity.nl/ws/portalfiles/portal/1439730/guid-55b44d63-b482-4e81-b66e-cfc1a4cef467-ASSET1.0.pdf>
- 3.6. *Venice Commission, Report on Exclusion of Offenders from Parliament*, CDL-AD(2015)036cor, 2015,
[https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2015\)036cor-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2015)036cor-e)

Шүүхийн шийдвэр

- 4.1. *헌법재판소 2011. 12. 29. 선고 2009헌마476 전원재판부 [공직선거법제250조등위헌확인] [헌집23-2, 806]*,
<https://casenote.kr/%ED%97%8C%EB%B2%95%EC%9E%AC%ED%8C%90%EC%86%8C/2009%ED%97%8C%EB%A7%88476>
- 4.2. *대법원 2009. 7. 23. 선고 2009도2649 판결 [공직선거법위반]*,
<https://casenote.kr/%EB%8C%80%EB%B2%95%EC%9B%90/2009%EB%8F%842649>

ХАВСРАЛТ

1. Хүснэгт 1. Гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон УИХ-ын гишүүдийн мэдээлэл

№	Нэр	Холбогдсон гэмт хэрэг	Парламентын жил	Шийдвэрлэсэн байдал
1.	Д.Баттулга	2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.	1996-2000	УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаанд гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлж, тендер будилуулж, авлига авсан гэх хэрэгт холбогдож 7 жилийн хорих ял оногдуулсан.
2.	С.Батчулуун	Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах		
3.	Д.Энхбаатар			
4.	Д.Дондог	2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 4 дэх хэсэг. Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах	2008-2012	УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа түүнийг Эрүүгийн хуулийн 148.4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоож 10.1 жилийн хорих ял оногдуулсан.
5.	Ц.Батбаяр	2002 оны Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 263 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	2008-2012	УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа түүнийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 150.3 дугаар зүйл ангид заасан гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоож 5.1 жилийн хорих ял оногдуулсан.
6.	Д.Гантулга	2015 оны эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Хүчиндэх	2016-2020	2018 оны 6 дугаар сард өөрийн хүсэлтээр УИХ-ын гишүүний бүрэн эрхээсээ чөлөөлөгдсөн бөгөөд 2019 оны 11 дүгээр сард Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс түүнд 2 жилийн хорих ял оногдуулсан.
7.	Б.Батзориг	2015 оны Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4, 22.5 дугаар зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авсан,	2016-2020	Монгол Улсын Их Хурлын 2020.04.17-ны өдрийн 27 дугаар тогтоолоор гишүүнээс чөлөөлсөн. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн болохоо хүлээн зөвшөөрсөн.

		хахууль өгсөн.		Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс түүнийг нийтийн албанд томилогдох эрхийг 5 жилийн хугацаагаар хасах, 40 сая төгрөгөөр торгох ял оногдуулсан.
8.	Н.Номтойбаяр	2015 оны Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Хайнга хандах	2020-2024	УДШ-ийн 2021.01.22-ны өдрийн 60 дугаартай тогтоолоор Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоож, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээр хасаж, 1 жил хорих ял оногдуулсан.
9.	Д.Цогтбаатар	2015 оны Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	2024-2028	УДШ-ийн 2024.12.16-ны өдрийн тогтоолоор Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоож, нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил хасаж, 20 сая төгрөгийн торгох ял оногдуулсан.